



“ИХ ХУРАЛДАЙ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР



01 ХАРАГДАХ БАЙДАЛ



•1206 онд Их Эзэн богд Чингис хаан эсгий туургатныг нэгэн төрийн дор хурааж Онон мөрний тэргүүнээ Их хуралдай хийж, Их Монгол Улсыг байгуулж, Чингис хаанд “хаан” цол өгсөн түүхт газар баригдаж буй тус цогцолбор нь төрийн есөн хөлт цагаан тугийн билэгдэлтэй байх юм.

•Цогцолборын гол өргөө нь 21 м өндөр, 300 хүний багтаамжтай, мөнгөлөг цагаан ордон байна.

Байршил: Биндэр сум

Төсөл эхэлсэн огноо: 2018 оны 8 сар

Нийт санхүүжилт: 3,9 тэрбум төгрөг

Ажлын явц: 72 %

Ашиглалтанд орох хугацаа: 2023 он




БИНДЭР СУМАНД ЖУУЛЧНЫ БААЗ, АМРАЛТЫН ГАЗРЫН ЗОРИУЛАЛТААР ОЛГОХ БОЛОМЖТОЙ ГАЗРУУД




Тухайн суманд үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз 4, зочид буудал 1 байдаг. Аялалын улиралд бааз, буудал хүртээмжгүй болдог. 2022 онд Биндэр суманд дотоод 652, гадаад 100 жуулчид ирж амарсан. Түүхэн цогцолбор баригдсанаар жуулчдын урсгал нэмэгдэнэ.

Жуулчны баазын газар олгох боломжтой газрууд





“ИХ ЗАСАГ - ШИХИХУТАГ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР



Их Монгол Улсын их заргач Шихихутуг нь Монгол төрийн анхны бичмэл хууль болох Их засаг цаазыг бий болгож Их Монгол Улсад төдийгүй Эзэнт Гүрний харьяат улсуудад дайн дажингүй амар амгалан амьдрах үндэс суурийг тавьсан түүхэн хүн болно. Цогцолборын гол бэлэгдэл болсон хөшөөг жигүүрт мориор дүрсэлсэн. Тус цогцолборын барилга нь 60 метр урт, 9 метр өндөртэй өвөрмөц хийц бүхий байгууламж байх юм.

Байршил: Норовлин сум

Төсөл эхэлсэн огноо: 2019 оны 09 сар

Нийт санхүүжилт: 3,4 тэрбум төгрөг

Ажлын явц: 70%


Ашиглалтанд орох хугацаа: 2024 он



НОРОВЛИН СУМАНД ЖУУЛЧНЫ БААЗ, АМРАЛТЫН ГАЗАР БАЙХГҮЙ. АЯЛАЛЫН ГОЛ МАРШРУТЫН ТӨВ ЗАМ ДАГУУ БАЙРЛАДАГ, “ИХ ЗАСАГ - ШИХИХУТАГ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР ЗЭРЭГ НЬ ОНЦЛОГ ДАВУУ ТАЛТАЙ ЮМ. ШИНЭЭР ЖУУЛЧНЫ БААЗЫН ЗОРИУЛАЛТТАЙ ОЛГОХ ГАЗАР 10 БАЙНА.




Тухайн суманд жуулчны бааз, амралтын газар байхгүй. Аялалын гол маршрутын төв зам дагуу байрладаг, “ИХ ЗАСАГ - ШИХИХУТАГ” аялал жуулчлалын цогцолбор зэрэг нь онцлог давуу талтай юм. Шинээр жуулчны баазын зориулалттай олгох газар 10 байна.





"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО" АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР



Байршил: Дэлгэрхаан сум
Төсөл эхэлсэн огноо: 2020 оны 05 сар
Нийт санхүүжилт: 3,1 тэрбум төгрөг
Ажлын явц: 50%
Ашиглалтанд орох хугацаа: 2024 он


Хэрлэнгийн Хөдөө арал бол Чингис, Өгөдэй, Мөнх, Есөнтөмөр тэргүүтэй үе үеийн их хаад хаан ширээнээ заларч, удаа дараа Их хуралдай чуулж, Чингис хааны үеийн түүх, утга соёлын гайхамшигт дурсгал “Монголын нууц товчоон”-г туурвисан түүхэн чухал дурсгалт газар бөгөөд ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтад “Хэрлэнгийн Хөдөө арал дахь Монголын Эзэнт Гүрний археологийн дурсгал түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар” нэрээр 2015 онд бүртгэгдсэн билээ. 27 метр өндөртэй энэ цогцолбор есөн давхар байшинтай тэнцэхүйц хэмжээтэй. Дотор нь “Монголын нууц товчооны Дэлхийн ном” музей байгуулж, нууц товчооны 30 хэлээр хэвлэсэн 300 гаруй номыг дэлгэх юм.



ДЭЛГЭРХААН СУМАНД ЖУУЛЧНЫ БААЗ, АМРАЛТЫН ГАЗРЫН ЗОРИУЛАЛТААР ОЛГОХ БОЛОМЖТОЙ ГАЗРУУД




Тухайн суманд жуулчны бааз 1, амралт сувилалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж 11, Аварга тосон нуур дагасан иргэдийн гэр буудал 106 ажиллаж байна. Зуны гурван сард 20000 орчим амрагч ирж амардаг ба энэ үед гэр буудлын хүрэлцээ хүрдэггүй. Түүхэн цогцолбор ашиглалтанд орсоноор урсгал нэмэгдэж жуулчны баазын хүртээмж зайлшгүй шаардлага үүснэ. Шинээр жуулчны баазын зориулалттай олгох газар 10 байна.





“ТЭНГЭРИЙН АНДГАЙ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР



•Монголын Нууц Товчоонд тэмдэглэгдсэн Хөхүүрийн талд Тэмүжин Боорчи хоёр анх танилцан, андгай тангараг өргөж, улмаар хулгайд алдсан найман шарга морио буцаан авсан тухай түүхэн баримт бий. Үүнээс үзвэл:

•Тэмүжин нэгэн насны салшгүй анд Боорчи лугаа учирсан

•Андгай тангараг тавьсан

•Уран барималч А.Очирболдын “Тэнгэрийн андгай” нэртэй уран баримал нь тал нутгийн хоёр залуу баатар эрс бие биедээ агсрага бүсээ өгч, андгай тангараг тавих үеийн агшинг тэнгэрийн салхины эрч
•лээсэнд бие биеэ нэвт цоргин, төв, гүн хүндэтгэлтэй харж буйгаар дүрсэлсэн хүрэл цутгуур баримал юм.

•Байршил: Батноров сум

Уг цогцолбор нь ашиглалтанд орсон. Аялал жуулчлалын гол маршрутын дагуух төв замын дэргэд байралдаг.

Тухайн суманд жуулчны бааз байхгүй нь энэ төрлийн үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгж, иргэнд давуу тал юм.




БАТНОРОВ СУМАНД ЖУУЛЧНЫ БААЗ, АМРАЛТЫН ГАЗРЫН ЗОРИУЛАЛТААР ОЛГОХ БОЛОМЖТОЙ ГАЗРУУД



Батноров сум нь түүхэн газар нутаг, тэнгэрийн андгай хөшөөт цогцолбор баригдсан. Адуун соёл хөгжсөн Талын түмэн адуу эвент арга хэмжээ зохион байгуулагддаг. жуулчны бааз, амралтын газар байхгүй. Аялалын гол маршрутын зам дагуу байрладаг зэрэг нь онцлог давуу талтай юм. Тус суманд 6 байршилд амралтын газар, жуулчны баазын зориулалтаар газар олгох боломжтой.

Жуулчны баазын газар олгох боломжтой газрууд



Таних тэмдэг

- ★ Олгох боломжтой газар
- ★ Сумын төв
- Сумын хил
- ★ ЖУУЛЧНЫ_БААЗ
- Тэнгэрийн андгай цогцолбор

0 1.5 3 6 9 12 Miles 1:500,000

GUIDE → ЖАРГАЛТХААН СУМ – ӨМНӨДЭЛГЭР СУМ – РАШААН ХАД – ӨГЛӨГЧИЙН ХЭРЭМ – БИНДЭР СУМ – БАЯН-АДАРГА СУМ – ДАДАЛ СУМ

SR 20 MR 520

Нийт зам: 1000 + 220 км (айрлцоогоор)
Аяллын хөнгө: 6-7 ба 7-8 өдөр

Тэмдэг, тэмдэглэгээ

- ★ Нийслэл
- ★ Хот
- Сумын төв
- Аяллын цэг
- Засмал зам
- Шороон зам
- Аяллын чиглэл
- 50 Замын урт /км/
- Зочид буудал
- Жуулчны бааз
- Цайны газар
- Хүнс, барааны дэлгүүр
- Бэлэг дурсгалын дэлгүүр
- Шатахуун түгээгүүр
- Бие засах газар /00/

ТҮҮХЭН АЯЛЛЫН МАРШРУТ



ДАДАЛ СУМАНД ЖУУЛЧНЫ БААЗ, АМРАЛТЫН ГАЗРЫН ЗОРИУЛАЛТААР ОЛГОХ БОЛОМЖТОЙ ГАЗРУУД



Дадал сум нь Их эзэн Чингис хааны төрсөн түүхэн газар нутаг юм. Энд жуулчны бааз, амралтын газар 6 байдаг. Чингис хаан цогцолбор 2023.04.14 нд шав тавьсан. Тус суманд 11 байршилд амралтын газар, жуулчны баазын зориулалтаар газар олгох боломжтой.





Түүхэн цогцолборуудын менежментийг хэрэгжүүлэх:



Түүхэн аялал жуулчлалын бүс нутгийн хүрээнд баригдаж буй цогцолборуудын ажлыг энэ онд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.


Түүхэн цогцолборуудыг ашиглалтанд оруулах бэлтгэл ажлыг хангаж, дэд бүтцэд холбох ажлууд хийгдэж байна. Цаашид газар зохион байгуулалтыг төлөвлөх, маршрутын дагуу түр буудаллах болон отоглох цэгүүд, жуулчны баазууд, зарим газарт зочид буудал зэрэг бүтээн байгуулалт хийгдэх нэн шаардлагатай байна. Мөн цогцолборуудын онцлогт тохируулан үзвэр үйлчилгээ (морьтон баатруудын үзүүлэх тоглолт, ардын урлагийн тоглолт, дуулалт жүжиг гэх мэт), эвент арга хэмжээнүүдийг бий болгоно. Цогцолборуудын орчмын газар зохион байгуулалтыг хийж, төсөл сонгон шалгаруулах замаар газар эзэмшүүлж цогцолборуудыг түшиглэн гадаад, дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, стандарт шаардлагад нийцсэн жуулчны бааз, зочид буудал, түр буудаллах цэг зэргийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барих таатай нөгцөлийг хамтран хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

Тиймээс энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой аж ахуй нэгж, иргэн хөрөнгө оруулагч та бүхэнтэй хамтран ажиллахад бэлэн байна.

ИХ ЗАСАГ-ШИХИХУТАГ –
НОРОВЛИН СУМ




МОНГОЛЫН ДАЛД УУЛ
УУРХАЙН МУЗЕЙ, СУРГАЛТ,
СУДАЛГАА, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ТӨВ – БЭРХ



ТЭНГЭРИЙН АНДГАЙ
БАТНОРОВ СУМ



МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО –
ДЭЛГЭРХААН СУМ



ИХ ХУРАЛДАЙ – БИНДЭР
СУМ



БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ӨВ БҮХИЙ ГАЗРУУДАД АРИУН ЦЭВРИЙН ГАЗАР, АВТО ЗОГСООЛ БҮХИЙ ОТОГЛОХ ЦЭГ БАЙГУУЛАХ БОЛОМЖТОЙ ГАЗРУУД



- Хэнтий аймгийн Онон балжийн байгалийн цогцолборт газарт 1 отоглох цэг байгуулсан.

Отоглох цэгүүд нь дараах бүрдэл хэсэгтэй байна.

1. Машины зогсоол
2. Тэмдэг, тэмдэглэгээ
3. Морины уяа
4. Мэдээллийн самбар
5. Майхан барих талбай
6. Ширээ, сандал
7. Ширээ, сандал бүхий дээвэртэй сүүдрэвч
8. Ил гал түлэх зориулалтын цэг
9. Шорлог хийх зуух
10. Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл бүхий галын саравч
11. Гэрэлтүүлэг шон
12. Спорт талбай
13. Явган хүний зам
14. Нийтийн ариун цэврийн байгууламж


№	Аймаг сум	Газрын байршил
1	Хэнтий аймаг, Баян-Овоо сум	Гүрэмийн нуур
2	Хэнтий аймаг, Биндэр сум	Яргуй хавцал
3	Хэнтий аймаг, Дадал сум	Онон балж БЦГ
4	Хэнтий аймаг, Өмнөдэлгэр сум	Балдан Бэрээвэн хийд
5	Хэнтий аймаг, Өмнөдэлгэр сум	Хангал нуур
6	Хэнтийн аймгийн Дадал сум	Хэнтийн аймгийн Дадал сум
7	Хэнтийн аймгийн Дадал сум	Онон балжийн БЦГХЗ, Тэнгэлэгийн адаг Баян -Овоогийн ар(Яргайт)
8	Хэнтийн аймгийн Дадал сум	Онон балжийн БЦГХЗ , Дэлүн болдогийн өвөр
9	Хэнтийн аймгийн Дадал сум	Онон балжийн БЦГХЗ
10	Хэнтийн аймгийн Дадал сум	Онон балжийн БЦГХЗ
11	Хэнтийн аймгийн Дадал сум	Онон балжийн БЦГХЗ



Жаргалтхаан суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барьсан түр буудаллах цэг



150м² үйлчилгээний барилга



Жаргалтхаан суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар түр буудлах цэг 240 өртөөг бариад байна. 2022.10 сараас 2023.03 сар хүртэл 5130 авто машин, 10260 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Цаашид хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрхаан, Батноров, Өмнөдэлгэр, Норовлин сумдад түр буудлах цэг барих ажлыг дэмжин ажиллахад бэлэн байна.



Аялал жуулчлалын тухай хууль шинчлэн батлагдсанаар



ᠬᠡᠨᠲᠡᠢ ᠤᠯᠤᠰ

Welcome to MONGOLIA

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ, ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЛЭЭ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу.

Тур оператор компанийн үйл ажиллагааны 100 хувийн орлогын албан татварт 2026 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл 100 хувийн татварын хөнгөлөлт үзүүлнэ.



ᠬᠡᠨᠲᠡᠢ ᠤᠯᠤᠰ

Welcome to MONGOLIA

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ, ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЛЭЭ

Улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш гурван жилийн хугацаанд Аялал жуулчлалын тухай хуулийн 5.2.3-т заасан гарааны компанийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварт 100 хувийн татварын хөнгөлөлт үзүүлнэ.



Аялал жуулчлалын тухай хууль шинчлэн батлагдсанаар



Улаанбаатар
Хэнтийн аймгийн төв

Welcome to
MONGOLIA

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ, ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЛЭЭ

Гадаад улсын жуулчинд нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг олгох эрх зүйн орчин бүрдэв. Гадаад улсаас Монгол Улсад 90 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэхээс бусад зорилгоор аялж байгаа гадаадын иргэний хувийн хэрэгцээнд зориулж Монгол Улсын нутаг дэвсгэрээс худалдан авсан бараанд төлсөн албан татварыг олон улсын нисэх онгоцны буудлын шалган нэвтрүүлэх хэсгээр гарсны дараа 100 хувь буцаан олгохоор тус тус заасан.



Улаанбаатар
Хэнтийн аймгийн төв

Welcome to
MONGOLIA

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ, ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЛЭЭ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу.

Аялал жуулчлалын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан аялал жуулчлалын байгууллага, отоглох цэг, авто замын дагуух түр амрах газар өөрийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангахуйц болгож засварласны болон стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж шинээр байгуулсны зардлыг ААН-ийн орлогын албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцно.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА



Photo by Bayar